

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа зохион байгуулж, 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Унгар улсаас Монгол улсад суугаа бүрэн эрхт Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр аймгийн Засаг даргын урилгаар тус аймагт албан ёсны айлчлал хийлээ. Уулзалтын үеэр хоёр тал өөрийн улс, орон нутгийн түүх соёл, онцлогийн талаар харилцан мэдээлэл хүргэж, цаашид боловсрол, соёл урлаг, нийгэм, аялал жуулчлалын салбарт хамтарч ажиллах талаар санал солилцсон. Мөн айлчлалын үеэр Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна аймгийн нэгдсэн эмнэлэгт иж бүрэн амьсгалын аппарат гардуулан өгсөн.

2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Засаг дарга, Онцгой комиссын гишүүдийн хамт улаан бүсэд буюу Коронавирус /ковид-19/-ын халдварын тусгаарлан эмчилгээний 5 байранд эмчлүүлж буй иргэдтэй уулзаж санал хүсэлтийг нь сонсож, улаан бүсэд ажиллаж байгаа эмч, сувилагч, асрагч нарын ажиллаж буй нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн.

Хүүхэд бүрт тэгш боловсролыг олгох зорилтын хүрээнд Мобиком Корпораци болон Дэлхийн Зөн ОУБ-аас “Smart Education” төслийг санаачлан хамтран хэрэгжүүлж, төслийн хүрээнд зохион бичлэг, гар зургийн уралдаан зохион байгуулж, шалгарсан 40 хүүхдэд шагналдыг гардуулан өглөө.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 192.2 сая төгрөгийн 22 нэр төрлийн PCR шинжилгээний тоног төхөөрөмж, 31.0 сая төгрөгийн оношлуурыг хүлээлгэн өглөө.

“Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/261 дүгээр захирамжаар 10 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулалтын өарга хэмжээ авч ажиллаж байна. 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт халдварын тоо 2902, эдгэрсэн 2339, эмчлэгдэж байгаа 552 иргэн байна. Гэрийн ажиглалтад 1518 иргэнд хяналт тавин ажиллаж байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхааран ажиллаж байна.

2021 оны 9 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 5,633.579 мянган төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6,291.319 мянган төгрөг төвлөрүүлж, 110 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 868.879 мянган төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 868.879 мянган төгрөг төвлөрүүлж 100 хувь, сумын төсвийн орлогод 644.516 мянган төгрөг төвлөрүүлэхээс 860.381 мянган төгрөг төвлөрүүлж 133 хувь, аймгийн төсвийн орлогод 4,120.184 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,562.059 мянган төгрөг төвлөрүүлж, 110 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

2021 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 657 болж, оны эхэн үетэй харьцуулахад 28-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Татвар төлөгчдийг хариуцлагын хэлбэрээр харуулбал ХК-1, ХХК-341, ББН-5, ЗБН-9, Хоршоо-24, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-64, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-206 байна.

Тайлант хугацаанд 1 аж ахуй нэгжид 2017-2020 оны татвар, санхүүгийн баримт материал, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 40034323.9 төгрөгийн зөрчил илрүүлэн 6012249.19 төгрөгийн нөхөн ноогдуулалтын акт үйлдсэн.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2021 оны 8 дугаар сард шилэн дансны хуулийн хэрэгжилт 9.8 хувь буюу өмнөх сарын хэрэгжилтээс 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.09.25		2021.09.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/
1	Өндөр настан	1831	7060232,2	1932	8003457,0
2	Хөгжлийн бэрхшээлтэй	332	1089576,1	311	945753,8
3	Тэжээгчээ алдсан	128	363728,4	122	372166,0
4	Үйлдвэрийн осол	27	123674,3	46	222101,4
Нийт дүн		2318	8637211,0	2411	9543478,2

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.09.25		2021.09.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	987	136214,8	818	90562,6
2	ЖБА тэтгэмж	306	536532,7	352	69340,5
3	Оршуулга	54	54000,0	67	67000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	3	4521,5	14	13024,8
5	Ажилгүйдэл	148	328261,3	160	336702,1
Нийт дүн		1498	1059530,3	1411	1200699,0

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.09.25	2021.09.25
Шинээр	319	215
Мөнгө тушаасан	541	506
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	134095,5	147166,4

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 365 заалт, 3667 хүний нэр, 358 байгууллагын нэр, 1060 газар зүйн нэр, 384 хуудас баримт программд холбосон. Архивын баримтаас 18 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 64
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 38
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 3
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 14
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 29
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 24

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 6
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 25
- Гэрээний бүртгэл - 94
- Барьцааны гэрээний бүртгэл - 229
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 5

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 4

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 16
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 124

Нийт 682 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 144 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 28, зөрчлийн 116 гомдол байна. Зөрчил гаргасан 81 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 24,350,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 86 хүнийг эрүүлжүүлж, 25 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 44 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан улсын хэмжээнд “Хичээл эхэллээ”, “Ятгах тусам нягтал” нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, жолооч нарт болон эцэг, эхчүүд бага насны хүүхдүүдэд хөдөлгөөнд соёлтой оролцохыг зөвлөж, хөдөлгөөн зохицуулалт, хэв журмын хамгаалалтын үүрэг гүйцэтгэн, сургалт, сурталчилгааны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ. Мөн “Ятгах тусам нягтал” арга хэмжээний хүрээнд иргэдэд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, зурагт хуудас тараан ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 15 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 4, зам тээврийн ослын 6, хулгайлах гэмт хэрэг 4, бусад хэргийн газрын үзлэгт 1 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 734 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулж буй “Хохирлоо төлөөд гэртээ харья-2021” 90 хоногийн аяны хүрээнд гэм хорын төлбөртэй хүмүүжигчдийн судалгааг гарган, хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, таниулгыг хийж, тайлант хугацаанд 2,850,000 төгрөгийн гэм хорын төлбөрийг барагдуулсан. Нэр бүхий 12 хүмүүжигчийг цалинтай ажлын байраар хангасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран хүнд машин механизмын оператор, зам барилгын машин механизмын оператор, гагнуурчин мэргэжлийн 1 жилийн сургалтад нийт 44 хүмүүжигчийг хамруулж, 9 дүгээр сард мэргэжлийн үнэмлэхийг олгосон. Мөн барилгын өрөг угсрагч, цахилгаанчны мэргэжлээр чадамжийн гэрчилгээ олгох сургалтад 40 хүмүүжигчийг хамруулсан.

2021 оны 9 дүгээр сард төлбөрийн 219 гүйцэтгэх баримт бичгийн 2970322,7 төгрөг төвлөрүүлэхээс 86 баримт бичгийн 606172,5 мянган төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 42.9 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар: Барилгын техникийн хяналтаар урьдчилан сэргийлэх шалгалтын явцад нийтийн орон сууцны гадна хана буулган хаалга гаргаж, өргөтгөл барьсан 2 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж тус бүр Зөрчлийн тухай хуулийн 12.1.9-д заасны дагуу 500,000 төгрөгөөр торгож, барилгыг анхны хэлбэрт оруулж янзлах улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар өгч, хугацаанд нь хэвийн байдалд оруулаагүй тохиолдолд шүүхэд шилжүүлэхээр ажиллаж байна.

Аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Сүмбэр сумын 1, 2, 3-р багийн хэмжээнд худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй хоол үйлдвэрлэлийн 8, хүнс үйлдвэрлэлийн 2, хүнсний худалдааны 38, эмийн сангийн 4, үсчин 2, хүнсний бус худалдааны 31, нийт 85 объектод коронавируст халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн халдвар хамгааллын дэглэм мөрдөж байгаа байдалд Онцгой байдлын газартай хамтран хяналт шалгалт хийж, 428 зөрчил илрүүлж, зөрчлийн 261 буюу 61 хувийг хяналтын явцад газар дээр нь арилгуулсан.

Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран 1 аж ахуй нэгжид төлөвлөгөөт бус шалгалтыг хийж цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм зөрчин үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлэн үйл ажиллагааг зогсоосон.

Энхтусдэм өрхийн Эрүүл мэндийн төвийн коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд эмчилгээний чанар, эм биобэлдмэлийн хяналтын чиглэлүүдээр хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан.

Эрүүл ахуй, Боловсрол, Хүнсний чанар стандартын хяналтын чиглэлээр Ерөнхий боловсролын 5 сургууль, СӨБ-ын 5 цэцэрлэгийг хамруулан Хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангагдсан байдалд 2 дугаар шатны урьдчилан сэргийлэх хяналтыг хийж гүйцэтгэсэн. Хувийн хэвшлийн 4 цэцэрлэг үйл ажиллагаа эхлүүлээгүй байсантай холбоотой шалгалтад хамрагдаагүй байна. Шалгалтаар нийт 136 зөрчил илрүүлж зөрчлийн 41 буюу 30%-ийг газар дээр нь болон хяналтын явцад арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бусад зөрчлийг арилгуулахаар 18 заалт бүхий 3 албан шаардлагыг 3 газарт хүргүүлсэн.

Хүнсний чанар, стандартын хяналтын, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид болон иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр усны 34, ариутгалын бодисын 2, хүнсний бүтээгдэхүүний 82, хүнсний ногооны 29, нийт 147 сорьцод 589 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэж, эерэг үзүүлэлт 3-ыг илрүүлсэн.

Онцгой байдлын газар: Онцгой байдлын ерөнхий газар болон Ус, цаг уур, орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны мэдээ, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх болон сэрэмжлүүлэг мэдээллийг Онцгой байдлын газрын “go.nema.gov.mn” сайтад байршуулан иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэж байна.

Монгол Улсын Шадар Сайд, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Уул уурхай баяжуулах үйлдвэр, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүрээнд “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, гамшгаас хамгаалах болон галыг аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Сургуулийн өмнөх боловсролын 23 бүлэг танхимаар, 20 бүлэг цахимаар хичээллэж байна. Цэцэрлэгийн хүүхдүүдийн 10 хувийг 14 хоног тутамд Коронавируст /ковид-19/халдварын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, 81 хүүхэд, 38 багшийг шинжилгээнд хамруулсан байна.

“Эх хэлний өдөр”-ийг угтан “Сайхан бичигтэн 2021” цахим уралдааныг зохион байгууллаа. Уралдааны 6-12 дугаар ангийн төрөлд 33 сурагч, 10-12 дугаар ангийн төрөлд 21 сурагч, 10 иргэн, байгууллагын төрөлд 8, нийт 158 бүтээл ирсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр анги, Хөгжим, Биеийн тамирын багш нарыг 2 өдрийн цахим программ нэвтрэх, арга аргачлал, оношлох үнэлгээ хийх арга зүйн цахим сургалтад хамрууллаа.

2021-2022 оны хичээлийн шинэ жилийн “Багш нарын бага хурал”-ыг 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдөр онлайн хэлбэрээр зохион байгуулж, 350 багш, албан хаагчид оролцлоо. Хурлаар хичээлийн шинэ жилийн зорилго, зорилтоо хэлэлцэж, өнгөрсөн хичээлийн жилийн тайлангаа танилцуулан, цар тахалтай үеийн боловсролын үйлчилгээг хүргэхэд анхаарч ажиллах зөвлөмжийг өгсөн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Хүүхдийн эрхийн тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлах, хуулийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Гэр бүлийн харилцаа” сэдвээр Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт сургалт зохион байгуулж, 13 албан хаагчийг хамруулсан.

Соёл, урлагийн чиглэлээр: Боржигин өв музейгээс хөдөөгийн багийн иргэдэд явуулын музей “VRBOX “ –ээр үйлчилж, 93 иргэнд гарын авлага, материал тарааж, соёлын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулсан.

Нийтийн номын сангаас Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн дагуу “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэд уншигчдад ном хэвлэлээ сурталчилж, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, сурталчилах арга хэмжээг цахимаар зохион байгуулсан.

Спортын чиглэлээр: Шагуйн харвааны Ахмадын улсын аварга шалгаруулах багийн тэмцээнд аймгийн ахмадын баг оролцож, мөнгөн медаль хүртсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2020 оны 08 сарын 20	2021 оны 09 сарын 20
Төрсөн эх	327	335
Гэрийн төрөлт	0	3
Амьд төрсөн хүүхэд	331	342
Амьгүй төрөлт	0	1
Нас баралт	54	56
Эмнэлгийн нас баралт	2	19
Хоног болоогүй нас баралт	0	5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	4259	3460
Амбулаторийн үзлэг	74068	67650
Халдварт өвчин	65	1940

2021 оны 8 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Монгол улсын Шадар сайдын зөвлөх П.Оюунчимэгээр ахлуулсан Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Г.Ганхуяг, Нийгмийн эрүүл мэндийн төвийн сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Байгальмаа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, эмч Б.Батсүх нарын хяналт шалгалтын ажлын хэсэг орон нутагт ажиллаж, Коронавируст халдварын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бэлэн байдалтай танилцан хариу арга хэмжээний багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгууллаа. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн Коронавирус / Ковид-19 /-аар өвчилж, эмчлүүлж байгаа эмчлүүлэгчдийн биеийн байдлыг үнэлж, тусламж үйлчилгээний бэлэн байдалтай танилцаж, эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.

Аймгийн хэмжээнд эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлж буй нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эрхлэгч нартай цахим уулзалт зохион байгуулж, цар тахлын цаг үеийн нөхцөл байдлыг танилцуулан эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг хангах талаар санал, чиглэл өгсөн.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар сургууль хамтран сувилахуйн 3 жилийн хугацаатай дипломын боловсрол олгох ангид орон нутгийн харъяат, цаашид аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллах хүсэлтэй 30 иргэнийг сонгон шалгаруулж, 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн орон нутагтаа цахим сургалтыг эхлүүлээд байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллээр хангах ганцаарчилсан үйлчилгээнд 6 иргэн, ажлын байрны захиалгын бүртгэлд 31 иргэн, ажилд зуучлах үйлчилгээнд 22 иргэнийг хамруулсан.

Шилдэг “СТАРТ –АП” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд гарааны бизнес эрхлэх хүсэлтэй 15-34 насны 21 бүлгийн 42 иргэнээс 210.0 сая төгрөгийн дэмжлэг хүссэн төслүүдийг хүлээн авч, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Сүмбэр нэхий” төсөлд 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг эргэн төлөгдөхгүй нөхцлөөр олгосон.

Тайлант хугацаанд 2018-2021 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 19 иргэний 8250.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд эргэн төвлөрүүлээд байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн 2020 оны жилийн эцсээр нийт 450997 толгой мал тоолуулж, 2021 оны хавар 123.0 мянган төл бойжуулсан. Төлийн орлого, зүй бус хорогдол, эдийн засгийн эргэлтэд оруулах, хүнсэнд хэрэглэх малыг тооцоолоод хонин толгойд шилжүүлснээр аймгийн хэмжээнд 536288 мал өвөлжиж, хаваржихаар байна. Энэ жил эдийн засгийн эргэлтэд 134781 толгой мал оруулан 4.3 мян.тн мах бэлтгэхээр тооцож, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

Аймаг дундын отрын бэлчээрийн даац багтаамжийг 5 цэгт тооцоолж, Малх отрын бүсэд хонин толгойд шилжүүлснээр 90.7 мянган толгой мал өвөлжих боломжтойг тодорхойлов.

Аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл хангах” албан даалгаврыг 358 малчин өрх буюу нийт малчин өрхийн 47 хувьд хүргүүлсэн. Сумдаас ирүүлсэн мэдээгээр малчдын түвшинд өвс, тэжээлийн бэлтгэл хангалт 1.4 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 2 иргэн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн сумдад хадланд гарч 9 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 390 тн өвс хадаж, 93 тн-ыг орон нутгийн малчдад захиалгаар нийлүүлсэн.

“Бэлчээр хамгаалах аян”-ны аяны хүрээнд 12 малчин өрх тэжээлийн ургамал тариалахаар үр авсанаас 10 малчин өрх 550 м.кв талбайд малын тэжээлийн ургамал /Овьёос/ тариалсан байна.

Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих, дэвшилтэт арга, технологийг судлах, нэвтрүүлэх, бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэх боломж, мэдлэгийг малчид, мэргэжилтнүүдэд олгох, мал аж ахуйг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтөд тусгах зорилгоор 2021 оны 9 дүгээр сарын 2, 3-ны өдрүүдэд “Тайшир өргөө” ХХК-ийн үхэр, хонины аж ахуй, тэжээлийн аж ахуйг малчин, мал аж ахуйн мэргэжилтнүүд, сумдын удирдлагууд, нийт 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр туршлага судлав.

“Шилмэл мал, шилдэг бүтээгдэхүүн 2021” цахим үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 11-ний өдөр хүртэл зохион байгуулж, сумын Засаг даргын шийдвэрээр борлуулалтын цэг тогтоож, уг цэгт халдвар хамгааллын дэглэм мөрдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулж байна. Үзэсгэлэнгийн талаарх болон “Шилмэл мал, шилдэг бүтээгдэхүүн” шалгаруулах ажлыг цахимаар зохион байгуулж, оролцогч 28 иргэн, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүний танилцуулгыг иргэдэд хүргэж байна.

Мал, амьтны халдварт паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ үргэлжилж байгаа бөгөөд тайлант сард мал угаалгын арга хэмжээнд 214.0 мянган толгой мал хамруулахаас 210 өрхийн 140.882 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 66 хувь, туулгалтад 178.4 мянган толгой мал хамруулахаас 73.9 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 41 хувь,

боловсруулалтад 185.7 мал, амьтан хамруулахаас 65.7 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 3 хувь, зоонозын халдварт бруцеллёзоос сэргийлэх вакцинжуулалтад 93.4 мянган толгой мал хамруулахаас 341 өрхийн 86.6 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 93 хувьтай байна.

Улсын хэмжээнд мал, амьтны зарим гоц халдварт өвчний гаралт, тархалт өндөр байгаатай холбогдуулан малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сум тус бүрт 7-14 хоногийн давтамжтайгаар зохион байгуулж, үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулж байна. Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багийн нутаг дэвсгэр дэх отор нүүдлийн хөдөлгөөнд хяналт хийхэд шинээр орж ирсэн отрын өрх байхгүй байна. Харин Шивээговь сумын нутаг дэвсгэрт Дундговь аймгийн Гурвансайхан сумын харьяат 2 өрх шинээр орж ирсэн ба хяналт, шалгалтаар шүлхийд мэдрэг мал нь дархлаажуулалтад хамрагдаагүйг илрүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр аймгийн Засаг даргын 2021 оны А/205 дугаар захирамжийг үндэслэн нутаг чөлөөлүүлэх арга хэмжээ авсан.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн 2021 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Сүмбэр сумын 4 дүгээр багт байрлах “Гашуун” булаг, Шивээговь сумын 2 дугаар багт байрлах “Мөнхтийн булаг”-ийн эхүүдийг хашиж хамгаалах ажлыг тухайн багийн малчид, иргэдийн нөхөрлөлтэй хамтран зохион байгууллаа.

Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2.6 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын 3 дугаар багт 2.8 га талбайн барилгын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг “Адил Оч” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэлээ.

Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутаг Цагаан усны эх орчмын жалганд их хэмжээний химийн бодис байна гэсэн иргэдийн мэдээллийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газрын ажлын хэсэг газар дээр нь очиж тухайн бодисоос дээж авч, ойр орчмыг тойруулан 60 м хашаа хайс барьж тусгаарлан, анхааруулга, аюултай бодисын тэмдэг тавьж ажиллалаа. Мөн тус бодисыг таних химийн шинжилгээг Батлан хамгаалахын их сургуулийн лабораторт хийлгүүлэн бүтцийг тодорхойлоод байна.

Засгийн газраас манай аймгийн “Сүмбэр” агнуурын бүс нутагт 2021 онд 2 угалз агнуулах зөвшөөрөл олгосны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Агнуурын бүс нутгийн агнуур хариуцагч “Степ номад” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, гэрээний дагуу 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр 1 угалз агнасан бөгөөд уг ажилд Сүмбэр сумын байгаль хамгаалагч Улсын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч нар хяналт тавин ажилласан.

Тайлант сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 2 удаагийн давтамжтайгаар сорьцыг 28 удаа, мөн шинжилгээг 12 удаагийн дээжинд шинжилгээ хийж, дундаж азотын давхар исэл (NO₂) 0.010 мкг/мг сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.013 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/161 дүгээр тушаалаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 9 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд ажиллаж цахим системүүдийн хэвийн үйл ажиллагааг нягтлах, тулгарч буй бэрхшээлүүд, авч хэрэгжүүлж буй ажлуудын талаар танилцсан.

Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх хугацаа нь болсон нийт 135 нэгж талбарт цахимаар мэдэгдэл хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд 36 нэгж талбарт захиалгат хянан баталгаа хийгдэж баталгаажуулаад байна.

Аймгийн хэмжээнд “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд Монголын барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Г.Шоовдор, аймгийн барилгын салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож, нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй болж өнгөрлөө.

Сүмбэр сумын 3 дугаар багт “Эрин зууны холбоос” ХХК-ийн дулаан блокны үйлдвэрлэл эрхэлж байгаа ажлын цех, бүтээгдэхүүнтэй 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр танилцаж, блокны түүхий эд материалыг шинжилгээнд хамруулах, эцсийн бүтээгдэхүүн материалд тохирлын гэрчилгээ баримт бичигтэй болгох талаар зөвлөгөө өгч ажилласан. Мөн дулаан блокны марк, дулаалгын нягтыг тодорхойлох, дүүргэгч материалуудын шинжилгээг хийж байна.

2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөл 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгад Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол шинэчилсэн дүрмийн дагуу Улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 30 ажилд барилга захиалагчийн хяналтыг 7-10 хоног тутамд ажлын талбайд очиж гүйцэтгэлтэй танилцаж, холбогдох зөвлөмж зөвлөгөөг өгч, хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 9 дүгээр сард гүйцэтгэгч байгууллагуудад барилгын ажлыг гэрээт хугацаанд гүйцэтгэх, хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, график хугацааг шинэчлэх талаар зөвлөмжүүдийг хүргүүлсэн. Мөн ажлын гүйцэтгэлтэй холбоотой ажил сайжруулах талаар “Говийн өгөөж” ХХК-д албан шаардлага, “Дэлгэр баясах зам трейд” ХХК-д мэдэгдэл хүргүүлээд байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 20 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 18 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 8 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 8 ажил, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлан 22 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлыг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулан ажиллаж байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд сумын аюулгүйн нөөцөд 300 боодол өвс, 20 шуудай тэжээл, 30 шуудай овъёос тус тус бэлэн байна.

“Сумын төвийн камержуулалт, галын дохиоллын систем нийлүүлэх, суурилуулах ажил”-ыг “Эрхэс теч аутсорсинг” ХХК-тай байгуулан гүйцэтгүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр ашиглалтад хүлээн авсан.

“Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа” нийтийг хамарсан ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 13-24-ний өдрүүдэд зохион байгуулж, цэцэрлэгт хүрээлэн болон сумын төвийн хойд хэсэгт шинээр тарьж ургуулсан /ногоон зурвас/ модны талбайн лууль, шарилжийг түүж, таримал модны усалгаа, арчилгааг хийж байна.

Шивээговь сум: “Сумын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах” ажлын хэсэг байгууллагуудаар шалгалт хийж, малчин, мал бүхий иргэдэд өвөлжилтийн бэлтгэл хангах албан даалгаврыг 99 өрхөд тарааж, малчин өрхүүдээр тойрч өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах талаар шаардлага тавьж ажилласан. Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 89.5 хувийн хэрэгжилттэй байна.

Төрийн цахим үйлчилгээний 54 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг өссөн дүнгээр 248 иргэнд олгож, 239000 төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг цахимаар зохион байгуулж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед дагаж мөрдөх дүрэм журмыг эцэг, эх, суралцагчдад видео хэлбэрээр цахим орчноор дамжуулан хүргэсэн. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид нийт 76 хүүхэд шинээр элсэн нийт 30 бүлэгт 811 сурагч, 67 багш, ажилтан, албан хаагчид ажиллаж байна.

“Шивээ овоо” ХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд сумын эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай 550 ширхэг түргэвчилсэн оношлуур, 10 ширхэг хөнжил, гудас олгож, хуучин эмнэлгийн тусгаарлан эмчлэх байранд хаалт хийн, байгууллагын гадна ариун цэврийн байгууламж, хог шатаах цэг зэргийг шинээр бариад байна.

Сумын булаг шандны эхийн хашааг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж, Тогоо булаг, Бэхтийн булаг, Нэртийн булгийн эвдэрч нурсан хашааг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ургац хураалтын ажил хугацаандаа явагдаж, 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 21.5 тн хүнсний ногоо, 26.1 тн төмс, нийт 47.6 тн төмс, хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сүмбэр сум: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 10 иргэн, аж ахуйн нэгж, Усан спорт сургалтын төв болон бялдаржуулах төвтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

2021 оны 8 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 10-ны хооронд сум хөгжүүлэх санд зээлийн үлдэгдэлтэй 2 иргэн зээлээ бүрэн төлж барагдуулж, нийт 13 зээлдэгч зээлийн эргэн төлөлт хийж, одоогийн байдлаар сум хөгжүүлэх санд нийт 315,1 сая төгрөг төвлөрөөд байна.

Ургац хураалтын ажил хугацаандаа явагдаж, 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 21,5 тн хүнсний ногоо, 26,1 тн төмс, нийт 47,6 тн төмс, хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,6 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сумын хэмжээнд 5 хадланч 42 иргэний бүрэлдэхүүнтэйгээр Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баяндун, Хэнтий аймгийн Өлзийтийн САА, Дархан суманд 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хадланд гарч, 1950 га талбайн зөвшөөрөл авсан ба одоогийн байдлаар 11500 боодол буюу 230 тн хадлан хадаад байна.

3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах 2000 м.кв барилгын туурь хог хаягдлыг түрж, булуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР